



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/314

Улаанбаатар хот

「Нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй барилга, байгууламжийг акталж, данс бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 129 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/776 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барилга барих болсонтой холбогдуулан Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 12 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй нийт 404,836,963 (дөрвөн зуун дөрвөн сая найман зуун гучин зургаан мянга есөн зуун жаран гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг актлан, данс бүртгэлээсээ хасч өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургууль (М.Туулсайхан)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй барилгыг буулгахад гарах хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглаж болох материалыг худалдан борлуулж 9,983,975 (есөн сая есөн зуун наян гурван мянга есөн зуун далан тав) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000925

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Хичээлийн 1 дүгээр байр	57	1964	ш	1	392,346,561	140,123,771.70	252,222,789.30
2	Цахилгааны шугам	57	1964	у/метр	45.7	674,532	240,904.20	433,627.80
3	Нийтийн зориулалттай талбай	24	1997	мкв	896.5	11,815,870	7,384,918.80	4,430,951.20
Нийт						404,836,963	147,749,594.70	257,087,368.30